



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ЗОРИГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 02. 20 № 3/251
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Татварын ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АППАРАТЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Утас: 261740
Цахим хаяг:
gunjigmaa@audit.gov.mn

Шинжээч: Д.Будмаа
Утас: 261740
budmaad@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

ХУУДАС

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	4
5. Материаллаг байдал.....	6
6. Дотоод хяналт.....	6
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	6
8. Шилэн дансны мэдээлэл.....	7
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	8
10. Гол, онцлог гүйлгээний талаар.....	8
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	9
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	9
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	9
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	10
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
17. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	10

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Татварын ерөнхий газрын аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд САГ/2017/247/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Татварын ерөнхий газрын аппаратын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Татварын ерөнхий газрын аппаратын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 03-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын шинжээч Д.Будмаа хэрэгжүүлэв.

Татварын ерөнхий газар аппаратын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-ны 04/259 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 2 дугаар сарын 03-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 23-нд Татварын ерөнхий газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, “Эдийн

засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангиллыг 4-5 дугаар хавсралт, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилалыг ашиглаж байна.

Харин тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулиудын нэг болох Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр шинэчлэн найруулсан мөн “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 32 дугаар тушаалыг хүчингүй болгож, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус бүр дагаж мөрдөхөөр заасан байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд Үндэсний татварын албаны эрхэм зорилго орших ба төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна.

Үндэсний татварын албаны чиг үүрэг нь:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 болон 16.4.5-т заасны дагуу Татварын ерөнхий газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Татварын ерөнхий газрын аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон

хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурьдвал дараах байдалтай байна.

- УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоол, ЗГ-ын 2016 оны 4 дүгээр тогтоолын дагуу Гааль, Татварын ерөнхий газрыг татан буулгасан. Татварын ерөнхий газар болгон зохион байгуулсантай холбоотойгоор байгууллагын үйл ажиллагааг хэвийн хангах ажлын хүрээнд Татварын ерөнхий газар 2016 оны 01/538 албан бичиг Сангийн сайдруу явуулсан байна. Сангийн сайдын 2016 оны 372 дугаар тушаалын дагуу Сангийн сайдын 2016 оны төсвийн багцын “бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” арга хэмжээний төсвийн санхүүжилтээр нийт 182,7 сая төгрөг Татварын ерөнхий газрын нэмэлт санхүүжилтийн 900011418 дансанд шилжүүлсэн байна. Үүнээс тавилга, тоног төхөөрөмж 126.1 сая төгрөгөөр худалдан авч, урсгал засварт 47.4 сая төгрөг зарцуулж үлдэгдэл 9.2 сая төгрөгийг сангийн яам татан төвлөрүүлсэн байна.
- Байгууллагаас авах авлагын 99.3 хувь буюу 1,997.1 сая төгрөг нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээс үүссэн авлагын үлдэгдэл байна. Үүний 1,747.9 сая төгрөг нь 2013 онд үүссэн бол 249.2 сая төгрөг 2015 онд, 63.9 сая төгрөг 2016 онд нэмэгдсэнээр 2,061.8 сая төгрөгөөр тайлагнасан байна. Сангийн яамтай дээрх авлагын дансны үлдэгдэлээр тооцоо нийлэхэд 2015, 2016 оны нэмэгдсэн 313.1 сая төгрөгийг авлагаар хүлээн зөвшөөрөөгүй тул жилийн эцсийн санхүүгийн тайланд тухайн дүнгээр залруулга хийж сангийн яамнаас авах авлагын дансны үлдэгдэл 1,748.8 сая төгрөгөөр тооцоо нийлж баталгаажуулжээ.
- Няравын кассын тайлангаар бэлэн мөнгөний данс эхний үлдэгдэл 0,1 сая төгрөг, тайлант хугацаанд харилцах данснаас нийт 123.6 сая төгрөгийн орлогыг бүртгэж, 120.6 сая төгрөгийг зарцуулж, 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Татварын ерөнхий газрын даргын 2013 оны 104 дүгээр тушаалаар баталсан “Үндэсний татварын албаны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горим”-ыг мөрдөн ажиллаж байна.

Татварын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа санхүүгийн программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “энгийн” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тайлант хугацаанд Татварын ерөнхий газрын аппарат нь санхүүгийн бүртгэлээ Интер-Актив ХХК-ний санхүүгийн “Emerald”, цалингийн “Payroll” програмаар тус тус хөтөлж, санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Материаллаг байдлыг тодорхойлох

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2016 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 209.4 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

Зургаа. Дотоод хяналтын талаар

Татварын Ерөнхий Газрын Дотоод аудитын газар нь Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн “Гааль, татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 03 дугаар тушаалын 1.10-т заасны дагуу “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар” нэртэйгээр зохион байгуулагдаж, газрын дарга, улсын ахлах байцаагч 2, улсын байцаагч 12, нийт 15 орон тоотойгоор ажиллаж байгаад УИХ-ын 12 дугаар тогтоол, ЗГ-ын 4 дүгээр тогтоолоор шинэ бүтэц зохион байгуулалтаар Дотоод аудитын газар нэртэйгээр хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит гэсэн үйл ажиллагааны үндсэн 2 чиглэлээр газрын дарга, татварын улсын ахлах байцаагч 2, татварын улсын байцаагч 6 гэсэн орон тоотой ажилласан байна.

Дотоод аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Татварын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох, дотоод аудитыг бэхжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх 11 ажил хийхээр төлөвлөн, төлөвлөсөн ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 16 зөвлөмж өгч, ТЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үүрэг чиглэл өгч ажилласан байна.

ТЕГ-ын дотоод аудитын газраас тус байгууллагын аппаратын 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд тухайлсан аудит хийж, зөвлөмж өгөөгүй ба байгууллагын дотоод бүтэц нэгжүүдийн сар бүрийн төлөвлөгөөт ажлын биелэлтэд үнэлгээ хийж, дүнг нэгтгэн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Татварын ерөнхий газрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс

гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Татварын ерөнхий газрын аппаратын 2016 оны төсөв нийт санхүүжилтийн зардлыг 8,785.2 сая төгрөгөөр баталснаас урсгалаас санхүүжих 6,658.2 сая, өөрийн орлогоор санхүүжих 2,127.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тус тус баталсан байна.

Тус байгууллага нь 2016 онд гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал төсвийн санхүүжилтэд 6,995.3 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,365.0 сая, үйл ажиллагааны бус орлогоос 111.4 сая төгрөгийн орлогыг тус бүр орлогоор бүртгэж, урсгал зардалд 8,295.4 сая төгрөгийг зарцуулж, 2,176.3 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлж, 3.0 сая төгрөг кассанд үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн дансаар НӨАТУС-ын урамшууллын 3,815.1 сая төгрөг, Мэдээлэл технологийн улсын төсөвт үйлдвэрийн газрын цалин 1,072.5 сая төгрөг, Сангийн сайдын багцаас 270.9 сая төгрөг нийт 5,158.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүртгэсэн. Гүйцэтгэлээр НӨАТУС-ын урамшуулалд 3,593.9 сая төгрөг, Мэдээлэл технологийн улсын төсөвт үйлдвэрийн газрын цалин 1,072.5 сая төгрөг, тавилга, тоног төхөөрөмж 126.1 сая, урсгал засварын зардалд 47.4 сая төгрөг, нүүлгэлтийн зардал 3.3 сая төгрөг, нэг удаагийн буцалтгүй тусламж 25.0 сая төгрөг зарцуулж 290.3 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Барьцаа хөрөнгийн 900011312 данс дахь 506.3 сая төгрөг нь Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн конторын барилгын гүйцэтгэлийн чанарын баталгааны барьцааг 3 жилийн хугацаатай байршуулсан байна.

Өөрийн орлогын гүйцэтгэлийн талаар : Нийт өөрийн орлогын гүйцэтгэл 3,476.4 сая төгрөг бөгөөд төлөвлөгөөнөөс 63.0 хувь буюу 1,349.4 сая төгрөгөөр илүү байна.

Өөрийн орлогын судалгаа:

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая.төг/ Зөрүү
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,782.5	3,365.0	(1,582.5)
2	Туслах үйл ажиллагааны орлого	344.5	111.4	233.1
3	Дүн	2,127.0	3,476.4	(1,349.4)

Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

- Аудитын явцад тус байгууллагын ВЭБ хуудас дахь “Шилэн данс цэс”-д байршуулсан мэдээлэлтэй танилцахад ЗГ-ын 2016 оны 4 дүгээр тогтоолоор шинээр байгуулагдсанаас хойших 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд хийсэн үйл ажиллагаа хамрагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 9-12 сарын нийт 1,552.5 сая төгрөгийн 22, зарлагын нийт 2,410.8 сая төгрөгийн 39 ажил гүйлгээг тус тус байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан байна.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд холбогдох дансдад нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоол, ЗГ-ын 2016 оны 4 дүгээр тогтоолоор төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Гааль, Татварын ерөнхий газрыг татан буулгасны дагуу тус байгууллагын дуусгалтын болон эхлэлтийн балансын бусад ажил гүйлгээнд завсрын аудитаар тулгалт хийсэн.

Завсрын аудитаар Гааль, татварын ерөнхий газрыг татан буулгах хаалтын баланс, Татварын ерөнхий газрын эхлэлтийн балансад Гаалийн ерөнхий газрын Аж ахуй үйлчилгээний албанаас шилжүүлсэн 35.8 сая төгрөгийн бараа материалыг бүртгэлд тусгаагүй байсныг илрүүлэн санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаар

Татварын ерөнхий газрын аппаратын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

- Гааль, татварын ерөнхий газрын дуусгалтын тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргахдаа батлагдсан төсвийн дүнг эхний хагас жилийн дүнгээр авч 7, 8 сарын батлагдсан төсвийг дутуу тайлагнаснаас 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 1,363.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.
- Урсгал санхүүжилтийн данснаас тайлант онд улсын мэдүүлэгийн маягт хэвлэх бэлтгэх зардалд 2,314.8 сая төгрөгийн зарцуулалт гарсан байна. Аудитын явцад тайлант хугацаанд худалдан бэлтгэсэн болон бусдад олгосон үнэт цаас, тооцоот маягтын ажил гүйлгээг тулган баталгаажуулахад бараа материалын дэлгэрэнгүй журналаар уг дансны эхний үлдэгдэл 3,111,780 ширхэг 81.4 сая, тайлант хугацаанд нийт 189,136,648 ширхэг 2,314.8 сая төгрөгийн үнэт цаас тооцоот маягтыг орлогоор авч, 189,098,094 ширхэг 2,339.8 сая төгрөгийн зарцуулалт хийж, 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3,150,334 ширхэг 56.4 сая төгрөгийн үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдэлтэй байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад Татварын ерөнхий газрын хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Гааль, Татварын ерөнхий газрын дуусгалтын тайлан болон бусад ажил гүйлгээ, харилцахын гүйлгээг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу 17 ажил гүйлгээгээр нийт 20.4 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь АОУС-250 “Санхүүгийн тайлангийн аудитад хууль тогтоомж, дүрэм журмыг анхаарах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байхаар зөвлөмж өгөх

2. Татварын ерөнхий газар, United pictures ХХК –ийн хооронд 2012 онд үүссэн 1.5 сая төгрөгийн авлага, 27.5 сая төгрөгийн өглөг, Тэрэлж сүйх ХХК-ийн хооронд 2010 онд үүссэн 1.3 сая төгрөгийн өглөг, бусад аж ахуй нэгж, байгууллагын хооронд 2011 онд үүссэн 12.6 сая төгрөг өглөг нийт 41.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлэн баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлангийн жилд авлага, өглөгийн тооцоог нийлж, баталгаажуулж байхаар зөвлөмж өгөх

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн тайланд материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Гааль, Татварын ерөнхий газар татан буугдаж Татварын ерөнхий газар болсонтой холбогдуулан албан хаагчдын бүтэц орон тоо, цалингийн сан, зэрэг дэвийн урамшуулалын зардлыг үзэх

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Татварын ерөнхий газрын аппаратын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,462.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 63.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 1,398.8 сая төгрөгийн залруулга хийсэн. Дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 3 зөвлөмж өгсөн болно.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газраас Татварын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 90 хувийг хэрэгжүүлж, 10 хувийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 6 дугаар сарын 28-ний өдрийн 02/3802 дугаар албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын ерөнхий газрын аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АППАРАТЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

САГ-ын дарга, тэргүүлэх аудитор:
С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г. Гүнжидмаа

Утас: 261740

Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Шинжээч: Д.Будмаа

Утас: 261740

Цахим хаяг:
budmaad@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
Газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Мөнгөн хөрөнгө.....3

Асуудал 2

Авлага, өр төлбөр.....4

2017 оны 2 дугаар сар

2010 оны 3 дугаар сарын
01

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Татварын ерөнхий газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Татварын ерөнхий газрын ерөнхий нягтлан бодогч О.Оюунтуяа, нягтлан бодогч Б.Бямбасүрэн болон бусад санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Мөнгөн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Гааль, Татварын ерөнхий газрын дуусгалтын тайлан болон бусад ажил гүйлгээ, харилцахын гүйлгээг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу 17 ажил гүйлгээгээр нийт 20.4 сая төгрөгийн зардал гаргасан байна.

ҮАГ-ын зөвлөмж

АОУС-250, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалтыг баримтлан ажиллах

Эрсдэлүүд

Анхан шатны баримтгүйгээр орлогыг бүртгэсэн байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Авлага, өр төлбөр	Тэргүүлэх ач холбогдол №2
-------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Татварын ерөнхий газар, United pictures ХХК –ийн хооронд 2012 онд үүссэн 1.5 сая төгрөгийн авлага, 27.5 сая төгрөгийн өглөг, Тэрэлж сүйх ХХК-ийн хооронд 2010 онд үүссэн 1.3 сая төгрөгийн өглөг, бусад аж ахуй нэгж, байгууллагын хооронд 2011 онд үүссэн 12.6 сая төгрөг өглөг нийт 41.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлэн баталгаажуулаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дах заалтыг баримтлан ажиллах

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, журам, заавар зөрчсөн байх;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.